



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТӨГТООЛ

2019 оны 1 дүгээр  
сарын 9-ний өдөр

Дугаар 8

Улаанбаатар  
хот

Журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 60.3-т заасныг үндэслэн Монгол Улсын  
Засгийн газраас ТӨГТООХ нь:

“Албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон  
тохиолдолд ар гэрт нь нэг удаагийн буцалтгүй тусlamж олгох журам”-ыг хавсралт  
ёсоор баталсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Сангийн сайд

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2019 оны 8 дугаар  
тогтоолын хавсралт

АЛБАН ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭХ ЯВЦАД ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АМЬ НАС  
ХОХИРСОН ТОХИОЛДОЛД АР ГЭРТ НЬ НЭГ УДААГИЙН БУЦАЛТГҮЙ  
ТУСЛАМЖ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд түүний ар гэрт Төрийн албаны тухай хуулийн 60.2-т заасан нэг удаагийн буцалтгүй тусlamж олгоход энэ журмыг мөрдөнө.

1.2. Төрийн тусгай албан хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад амь нас хохирсон тохиолдолд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг баримтална.

1.3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн үйлчлэлд хамаардаггүй төрийн тусгай албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусlamж олгоход энэ журамд заасныг баримтална.

1.4. “Албан үүргээ гүйцэтгэх явцад” гэдэгт ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг ажлын болон ажлын бус цагаар албан ажлын байр, ажил үүрэгт хамаарах бусад байршилд гүйцэтгэх, мөн гэрээс ажлын байр, ажлын байрнаас гэртээ харих, албан томилолтоор ажиллах явцыг хамааруулна.

Хоёр. Нэг удаагийн буцалтгүй тусlamж олгох

2.1. Хуульд өөрөөр заагаагүй бол албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд 60 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусlamжийг түүний ар гэрт нь ажиллаж байсан төрийн байгууллагаас олгоно.

2.2. Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд нэг удаагийн буцалтгүй тусlamж олгох талаар заасан бол төрийн албан хаагчийн ар гэр эдгээр тусlamжийн аль илүүг сонгох эрхтэй бөгөөд энэ тохиолдолд буцалтгүй тусlamжийг давхардуулан олгохгүй.

2.3. Төрийн албанаас чөлөөлөгдсөн иргэний амь насанд урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбогдуулан хохирол учруулсан бол энэ журамд заасан буцалтгүй тусlamжийг түүний ар гэрт мөн адил олгоно.

2.4. Байгууллагын дарга буцалтгүй тусlamжид шаардагдах хөрөнгийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэх бөгөөд хэрэв төсөвлөсөн хөрөнгө хүрэлцэхгүй бол үлдэгдэл зөрүүг дараагийн төсвийн жилд нөхөн олгоно.

2.5. Төрийн албан хаагчийн ар гэрт энэ журамд заасны дагуу олгосон буцалтгүй тусlamжийн хөрөнгийг холбогдох хуульд заасны дагуу гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ. Буцалтгүй тусlamжийн хөрөнгийг гэм буруутай этгээдээс нэхэмжлэх үүргийг тухайн байгууллагын төсвийн шууд захирагч хариуцна.